



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 5 сарын 08 өдөр

Дугаар 102

Улаанбаатар хот

### “Жинст-Увс” ХК-д “Ард санхүүгийн нэгдэл” хаалттай ХК-ийг нэгтгэхийг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.10, Компанийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 5.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Жинст-Увс” ХК-ийн гаргасан нэг бүр нь 1,000 /нэг мянга/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 1,665,938 /нэг сая зургаан зуун жаран таван мянга есөн зуун гучин найм/ ширхэг хувьцааг тус компанид нэгдэж буй “Ард санхүүгийн нэгдэл” хаалттай ХК-ийн хөрөнгөд ногдох нэг бүр нь 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 26,948,325 /хорин зургаан сая есөн зуун дөчин найман мянга гурван зуун хорин тав/ ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлэн нийт нэг бүр нь 1,000 /нэг мянга/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 28,614,263 /хорин найман сая зургаан зуун арван дөрвөн мянга хоёр зуун жаран гурав/ ширхэг хувьцаа болгон нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Лхагвасүрэн/-т үүрэг болгож, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦГХТ” ХХК /Ж.Байгалмаа/-д зөвшөөрсүгэй.

2. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орсонтой холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Жинст-Увс” ХК /Ж.Алтангүний/-д үүрэг болгосугай:

1/ “Жинст-Увс” ХК-ийн хувьцаа эзэмшигчид өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхийг хуульд заасан журмын дагуу хэрэгжүүлэх;

2/ Компанийг өөрчлөн байгуулж, нэгдэж байгаа компанийн өмчлөлийн хөрөнгийг “Жинст-Увс” ХК-д шилжүүлэх, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн, шинэчилсэн дүрмийг хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж, Санхүүгийн зохицуулах хороонд холбогдох баримт бичгийн хамт ирүүлэх;

3/ 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд орсон өөрчлөлтийг тусгах;

4/ Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 443 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам”-д заасан мэдээллийг тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;

5/ Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 162 дугаар тогтоолоор баталсан “Компанийн засаглалын кодекс”-ыг үйл ажиллагаандаа чанд баримталж, хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалж ажиллах.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН